



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 6 (387)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- *Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийг товлон зарлах тухай*
- *Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэлийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг батлах тухай*
- *Итгэлцүүрийг шинэчлэн тогтоох, тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар
Улаанбаатар хот
2005 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ
Долоо хөног тутмын

Улаанбаатар хот

2005 оны хоёрдугаар сарын 14

№6 (387)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

560.	Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай	Дугаар 10	114
561.	Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай	Дугаар 11	114
562.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийг товлон зарлах тухай	Дугаар 12	114
563.	Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэлийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх тухай	Дугаар 15	114

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

564.	Хэлэлцээр батлах тухай	Дугаар 11	115
565.	Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг батлах тухай	Дугаар 12	115
566.	Журамд өөрчлөлт оруулах тухай	Дугаар 13	115
567.	"Улсын сайн малчин", "Улсын тэргүүний тариаланч хамт олон", "Улсын тэргүүний тариаланч"-ийг шагнах тухай	Дугаар 14	116
568.	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын албаны бүтцийг тогтоох тухай	Дугаар 15	116
569.	Журам батлах тухай	Дугаар 16	118
570.	Хөрөнгө гаргах тухай	Дугаар 17	120
571.	Төрийн өмчийн хорооны зарим гишүүнийг томилох тухай	Дугаар 20	120
572.	Итгэлцүүрийг шинэчлэн тогтоох, тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай	Дугаар 22	120
573.	Тогтвортой байдлын гэрээний загвар батлах тухай	Дугаар 24	121

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ		
2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр	Дугаар 10	Улаанбаатар хот
Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай		
Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 23.13-т заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:		
кодлох уялдуулсан системийн дагуу зааж мөрдүүлэх арга хэмжээ авахыг Засгийн газар /Ц.Элбэгдорж/-т даалгасугай.		
Гаалийн тарифын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан уг хуульд гаалийн татвараас чөлөөлөхөөр заасан барааны код, нэр төрлийг Барааг тодорхойлох,		
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА		
Д.ЛҮНДЭЭЖАНЦАН		
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ		
2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр	Дугаар 11	Улаанбаатар хот
Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай		
Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:		
"11.Усны хэрэг эрхлэх газар" гэж, "12.Ус, цаг уур, орчны шинжилгээний газар" гэснийг "12.Цаг уур, орчны шинжилгээний газар" гэж тус тус өөрчилсүгэй.		
1."Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг батлах тухай" Улсын Их Хурлын 2004 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн 14 дүгээр тогтоолын хавсралтын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг гэсэн хэсгийн "11.Ой, усны нөөцийн газар" гэснийг		
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА		
Д.ЛҮНДЭЭЖАНЦАН		
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ		
2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр	Дугаар 12	Улаанбаатар хот
Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийг товлон зарлах тухай		
Монгол Улсын Үндсэн хуулийн хорин таадугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулийн 9 дүгээр зүйлд заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:		
2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн анхны шатны сонгуулийн санал хураалтыг 2005 оны 5 дугаар сарын 22-ны өдөр явуулахаар тогтоосугай.		
3. Энэ тогтоолыг 2005 оны 3 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.		
1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийг 2005 оны 3 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэхээр товлон зарласугай.		
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА		
Д.ЛҮНДЭЭЖАНЦАН		
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ		
2005 оны 2 дугаар сарын 3-ны өдөр	Дугаар 15	Улаанбаатар хот
Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэлийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх тухай		
Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5-д заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:		
"Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэл"-ийн хүрээнд үргэлжлүүлэн хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Ц. Элбэгдорж/-т зөвшөөрсүгэй.		
Төрийн өмчийг 2005-2008 онд хувьчлах үндсэн чиглэлийн төслийг Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцэж батлах хүртэл төрийн өмчийг хувьчлах ажлыг Монгол Улсын Их Хурлын 2004 оны 10 дугаар тогтоолоор баталсан		
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА		
Д.ЛҮНДЭЭЖАНЦАН		

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

Хэлэлцээр батлах тухай

Олон улсын гэрээний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Пхеньян хотноо 2004 оны 12 дугаар сарын 21-ний өдөр гарын үсэг зурсан "Худалдааны тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах

Ардчилсан Солонгос Ард Улсын Засгийн газар хоорондын Хэлэлцээр"-ийг баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**
Ц.ЭЛБЭГДОРЖ
**ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ
САЙД**
С.БАТБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот

Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг батлах тухай

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг дор дурдсанаар тогтоосугай:

-Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (архивын тасагтай);

-Хууль зүйн хэлтэс (иргэний бүртгэл, мэдээллийн албатай);

-Санхүү, эдийн засгийн бодлого, зохицуулалтын хэлтэс (төрийн сангийн тасагтай);

-Нийгмийн бодлого, зохицуулалтын хэлтэс;

-Үйлдвэрлэл, дэд бүтэц, байгаль орчны бодлого, зохицуулалтын хэлтэс;

-Цэргийн штаб.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Аймгийн Засаг даргын Тамгын газрын ерөнхий бүтэц, орон тоо, удирдлагын бүдүүвчийг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2000 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 181 дүгээр тогтоолын 4 дүгээр зүйлд "-Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс", "-Тээврийн алба" гэж тус тус нэмж, 1 дүгээр зүйл, 4 дүгээр зүйлийн "-Нийгмийн халамж, үйлчилгээний төв", "-Хөдөлмөр эрхлэлтийн алба" гэснийг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**
Ц.ЭЛБЭГДОРЖ
**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА**
С.БАЯРЦОГТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр

Дугаар 13

Улаанбаатар хот

Журамд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

хүртэлх ..." гэж өөрчилсүгэй.

Засгийн газрын 2001 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн 150 дугаар тогтоолоор батлагдсан "Улсын сайн малчин шалгаруулах журам"-ын 2 дугаар заалтын "... 20 хүртэлх ..." гэснийг "... 25

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**
Ц.ЭЛБЭГДОРЖ
**ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ САЙД БӨГӨӨД
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙДЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ**
С.БАТБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот

"Улсын сайн малчин", "Улсын тэргүүний тариаланч хамт олон", "Улсын тэргүүний тариаланч"-ийг шагнах тухай

Хүнс, хөдөө аж ахуйн яамны саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Болзлын шаардлага хангаж, өндөр амжилт гаргасан Архангай аймгийн Батцэнгэл сумын Дэл багийн малчин Лхагвасүрэнгийн Айлтгүйбаатар, Баян-Өлгий аймгийн Толбо сумын 3 дугаар багийн малчин Салмений Кука, Баянхонгор аймгийн Богд сумын 3 дугаар багийн малчин Жамъянгийн Дэндэв, Баянхонгор аймгийн Баянбулаг сумын 1 дүгээр багийн малчин Чадраабалын Даваажаргал, Булган аймгийн Хутаг-Өндөр сумын Тээл багийн малчин Лувсандагвын Гомбодорж, Говь-Алтай аймгийн Тонхил сумын Бүс-Уул багийн малчин Дамдинхүүгийн Цасхүү, Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын Баян-Өндөр багийн малчин Намсрайдагвын Дашням, Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын 2 дугаар багийн малчин Баянтерийн Чулуун, Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Цагаанхад багийн малчин Цэндийн Пүрэвзав, Дундговь аймгийн Дэрэн сумын 4 дүгээр багийн малчин Доржпаламын Батгэрэл, Завхан аймгийн Завханмандал сумын Олонтүрүү багийн малчин Жүрмэдийн Шагдарсүрэн, Завхан аймгийн Ургамал сумын 5 дугаар багийн малчин Дагвадоржийн Наран, Өвөрхангай аймгийн Бүрд сумын 4 дүгээр багийн малчин Бадарчингийн Лхагваа, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын 4 дүгээр багийн малчин Цэндийн Сүхтоого, Сүхбаатар аймгийн Асгат сумын Дөхөм багийн малчин Лутсүхийн Дуламрагчаа, Сэлэнгэ аймгийн Баянгол сумын Хараа багийн малчин Авирын Жанлав, Төв аймгийн Баянжаргалан сумын 3 дугаар багийн малчин Доржийн Дашдондог, Төв аймгийн Эрдэнэсант сумын 3 дугаар багийн малчин Базарвааний Уламбаяр, Увс аймгийн Зүүнговь сумын Баяннуур багийн малчин Түгжээгийн Цэвээндорж, Увс аймгийн Түргэн сумын Рашаант багийн малчин Баярын Давааням, Ховд аймгийн Чандмань сумын Сүлжээ багийн малчин Жадамбын

Дулам, Ховд аймгийн Булган сумын Байтаг багийн малчин Лужингаагийн Даваа, Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын 1 дүгээр багийн малчин Санжжавын Жигжид, Хэнтий аймгийн Дархан сумын 1 дүгээр багийн малчин Намжилын Донойдоо нарыг "Улсын сайн малчин"-аар;

2. Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын "Атар трейд" ХХК, "Шаргал тариа" ХХК, Төв аймгийн Сүмбэр сумын "Өгөөж сүмбэр" ХХК-уудыг "Улсын тэргүүний тариаланч хамт олон"-оор;

3. Сэлэнгэ аймгийн Баянгол сумын иргэн Цэрэнпилийн Зундуй, Дархан-Уул аймгийн Орхон сумын иргэн Ядамжавын Бадрал, Увс аймгийн Улаангом сумын иргэн Дандарын Дэвээ, Баян-Өлгий аймгийн Сагсай сумын иргэн Точингийн Үрлээ, Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын иргэн Жылхыбайн Хуаныш, Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын иргэн Раднаабазарын Өлзийбат, Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын иргэн Вандансангийн Гомбо, Говь-Алтай аймгийн Шарга сумын иргэн Доржийн Бямбатөгс, Говь-Алтай аймгийн Тайшир сумын иргэн Сундуйн Сайханжаргал, Ховд аймгийн Мянгад сумын иргэн Азыханы Авдрахман нарыг "Улсын тэргүүний тариаланч"-аар тус тус шалгаруулсугай.

4. "Улсын сайн малчин", "Улсын тэргүүний тариаланч хамт олон", "Улсын тэргүүний тариаланч"-д олгох тэмдэг, үнэмлэх, дурсгалын зүйлд шаардагдах 20.0/хорин/ сая төгрөгийг төсвийн багцаасаа гаргахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Тэрбишдагвад зөвшөөрсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Ц.ЭЛБЭГДОРЖ

**ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ САЙД БӨГӨӨД
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙДЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ С.БАТБОЛД**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр

Дугаар 15

Улаанбаатар хот

**Нийслэлийн Засаг даргын Тамгын газар,
Захирагчийн ажлын албаны
бүтцийг тогтоох тухай**

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэг, Нийслэлийн эрх зүйн байдлыг тухай хуулийн 8 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг дор дурдсанаар тогтоосугай:

-Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (олон нийттэй харилцах болон хяналт-шинжилгээ, үнэлгээний албатай);

-Хотын хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс;
 -Нийгмийн хөгжлийн хэлтэс;
 -Санхүү, эдийн засаг, төрийн сангийн хэлтэс;
 -Хууль зүйн хэлтэс;

-Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс;
 -Цэргийн штаб.

2. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны бүтцийг дор дурдсанаар тогтоосугай:

-Хот тохижилтын хэлтэс;
 -Инженерийн байгууламжийн хэлтэс;
 -Үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтэс;
 -Аялал жуулчлалын хэлтэс.

3. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын орон тооны хязгаарыг 70 хүртэл, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны орон тооны хязгаарыг 35 хүртэл, нийслэлийн дүүргүүдийн Засаг даргын Тамгын газрын орон тооны хязгаарыг Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүрэгт тус бүр 40 хүртэл, Багануур, Налайх дүүрэгт тус бүр 33 хүртэл, Багахангай дүүрэгт 22 хүртэл байхаар тогтоосугай.

4. Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий дараахь хэрэгжүүлэгч агентлагуудыг ажиллуулахаар тогтоосугай:

- 1/Эрүүл мэндийн газар;
- 2/Бивийн тамир, спортын хороо;
- 3/Хүүхэд, залуучуудын газар;
- 4/Байгаль хамгаалах газар;
- 5/Боловсрол, шинжлэх ухааны газар;
- 6/Соёл урлагийн газар
- 7/Иргэний бүртгэл, мэдээллийн алба;
- 8/Хөдөлмөр, нийгмийн хамгааллын газар (Хөдөлмөрийн биржтэй);
- 9/Нийтлэг үйлчилгээний газар;
- 10/Хүнс, хөдөө аж ахуйн газар;
- 11/Мал эмнэлгийн газар;
- 12/Хот төлөвлөлт, эрдэм шинжилгээ, зураг төслийн хүрээлэн;
- 13/Авто замын газар;
- 14/Хөрөнгө оруулалтын газар;
- 15/Өмчийн харилцааны газар;
- 16/Мэдээллийн технологийн газар;
- 17/Архивын газар;
- 18/Татварын газар;
- 19/Цагдаагийн газар;
- 20/Статистикийн газар;
- 21/Нийгмийн даатгалын газар;
- 22/Мэргэжлийн хяналтын газар;

23/Газрын алба;
 24/Гамшгаас хамгаалах штаб (нөөцийн албатай);

25/Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн алба.

5. Дүүргүүдийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлаг, Улаанбаатар хотын Захирагчийн харьяа газруудын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоон мөрдүүлэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч М.Энхболдод зөвшөөрсүгэй.

6. Мэдээллийн технологийн газар байгуулагдсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын алба, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, Улаанбаатар хотын Захирагчийн харьяа газруудын үйл ажиллагаанд "Цахим засаглал"-ыг нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлж, төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүнд суртал, чирэгдлийг арилгах, үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах арга хэмжээ авч ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч М.Энхболдод үүрэг болгосугай.

7. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын албаны бүтцийг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2000 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 185 дугаар тогтоол, "Тогтоолд нэмэлт оруулах тухай" Засгийн газрын 2001 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн 56 дугаар тогтоол, "Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2003 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн 7 дугаар тогтоолын 2, 3 дугаар зүйл, "Тогтоолд нэмэлт оруулах тухай" Засгийн газрын 2003 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн 9 дүгээр тогтоол, "Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2003 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн 12 дугаар тогтоолын 2 дугаар зүйл, "Тогтоолд өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын 2003 оны 9 дүгээр сарын 8-ны өдрийн 201 дүгээр тогтоол, "Тогтоолд өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын 2004 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн 182 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
 ЕРӨНХИЙ САЙД** **Ц.ЭЛБЭГДОРЖ**

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
 ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
 ЭРХЛЭХ ГАЗРЫН
 ДАРГА** **С.БАЯРЦОГТ**



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр

Дугаар 16

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Нийгмийн халамжийн тухай хуулийн 16.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Олон хүүхэдтэйн тэтгэмж олгох журмыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ц.Баярсайханд, сум, хороодод ажиллах орон тооны бус зөвлөлийг байгуулж, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлж ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Тэтгэмж, тусламжийн хэмжээг тогтоох тухай" Засгийн газрын 2002 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 262 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн "... олон хүүхэдтэй өрхийн нэг хүүхдэд жил бүр олгох тэтгэмжийн хэмжээг 6000 төгрөгөөр" гэснийг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Ц.ЭЛБЭГДОРЖ

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,
ХӨДӨЛМӨРИЙН САЙД Ц.БАЯРСАЙХАН

Засгийн газрын 2005 оны 16 дугаар тогтоолын хавсралт

ОЛОН ХҮҮХЭДТЭЙН ТЭТГЭМЖ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

заасан холбогдох материалын хамт харьяалах баг, хорооны Засаг даргад ирүүлнэ.

1.1. Нийгмийн халамжийн тухай хуулийн 16.1-д заасан олон хүүхэдтэйн тэтгэмж (цаашид "тэтгэмж" гэнэ)-ийг олгоход энэхүү журмыг баримтална.

3.3. Баг, хорооны Засаг дарга энэ журмын 3.1, 3.2-т заасан иргэдийн өргөдөл, холбогдох материалыг хүлээн авч, хянан баталгаажуулна.

Хоёр. Шалгуур үзүүлэлт

2.1. Тэтгэмжид хамрагдах өрх нь амьжиргааны доод түвшингээс доогуур орлоготой, 0-18 хүртэл насны гурав ба түүнээс дээш хүүхэдтэй байна.

3.4. Сум, хорооны нийгмийн ажилтан нь Засаг даргаас өгсөн үүргийн дагуу тухайн өрхийн амьжиргааны түвшинг энэ журмын 2.3-т заасан аргачлалын дагуу үнэлж тэтгэмж олгох эсэх саналаа бэлтгэнэ. Нийгмийн ажилтны бэлтгэсэн саналыг сум, хорооны Засаг дарга хянан сум, хорооны орон тооны бус зөвлөлд оруулж хэлэлцүүлнэ.

2.2. Хүүхэд сургууль завсардаагүй, заавал хийх дархлаажуулалтад бүрэн хамрагдсан, гэр орондоо хүмүүжиж байгаа, хүүхдийн хүнд тэвчшгүй хэлбэрийн хөдөлмөр эрхлэхгүй байгаа зэрэг нь хүүхдийн мөнгө олгох нөхцөл болно.

3.5. Сумын зөвлөл нь багийн Засаг даргын баталгаажуулсан өрх бүрийн асуудлыг хэлэлцэн шийдвэр гаргана. Энэ шийдвэрийг үндэслэж нийгмийн ажилтан тэтгэмж авах өрх бүрт хувийн хэрэг нээж, жагсаалтыг аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст хүргүүлнэ.

2.3. Тухайн өрхийн амьжиргааны түвшинг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын хамтарсан тушаалаар баталсан "Өрхийн амьжиргааны түвшинг үнэлэх аргачлал"-ын дагуу тодорхойлно.

3.6. Хорооны Засаг дарга нь хорооны зөвлөлийн хурлын шийдвэрийг тэтгэмжид хамрагдах өрхийн бичиг баримтын хамт дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст хүргүүлнэ.

Гурав. Тэтгэмжид хамрагдах хүсэлтийг хянан шийдвэрлэх явц

3.1. Тэтгэмжид хамрагдахыг хүссэн иргэн тэтгэмж олгохыг хүссэн өргөдлийн маягтыг амьжиргааны түвшинг тодорхойлох асуулгын хамт бөглөж, хүүхдийн төрсний гэрчилгээ, өрх (баг)-ийн эмчийн болон сургуулийн захиргааны тодорхойлолтыг эх (эцэг, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигч)-ийн иргэний үнэмлэхийн хуулбарын хамт баг, хорооны Засаг даргад ирүүлнэ.

3.7. Дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс бичиг баримтыг хянан үзэж, тэтгэмж олгох өрхөд хувийн хэрэг нээх бөгөөд хороодын зөвлөлөөр хэлэлцүүлсэн хугацааг оролцуулан ажлын 14 хоногийн дотор асуудлыг эцэслэн хянаж шийдвэрлэнэ.

3.2. Гурав дахь хүүхдээ төрүүлсэн болон үрчлэн авсан өрх хүүхдээ төрүүлсэн болон үрчлэн авснаас хойш 4 долоо хоногийн дотор хүүхдийн мөнгөн тэтгэмж авах хүсэлтээ энэ журмын 3.1-д

3.8. 2005 оны I улиралд багтаан бичиг баримтаа бүрдүүлсэн өрхийн тэтгэмжийг 2005 оны 1 дүгээр сарын 1-нээс тооцон олгох бөгөөд 4 дүгээр сарын 1-нээс хойш бичиг баримт нь бүрдсэн бол тухайн өдрөөс хойшхи хугацааны тэтгэмжийг тооцож олгоно.

3.9. Сарын дундуур шинээр тэтгэмж тогтоогдох буюу хасагдах хүүхдийн хувьд тэтгэмжийг тухайн сард ногдох өдрөөр тооцож олгоно.

Дөрөв. Зөвлөлийн эрх, үүрэг

4.1. Тэтгэмж авах өрхийг тогтоох үүрэг бүхий сумын зөвлөлийн бүрэлдэхүүнд сумын Засаг дарга, нийгмийн ажилтан, сумын эмнэлгийн эрхлэгч (эмч, багийн бага эмч), цагдаагийн ажилтан, сургуулийн нийгмийн ажилтан, багийн Засаг дарга болон сумын иргэдийн төлөөлөл болох 2-оос дээшгүй хүн орж болох бөгөөд зөвлөлийн бүрэлдэхүүнийг сумын Засаг даргын санал болгосноор сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид батална. Сумын Засаг даргын Тамгын газрын дарга нь зөвлөлийн нарийн бичгийн дарга байна.

4.2. Хороодын зөвлөлд хорооны иргэдийн Нийтийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга, цагдаагийн ажилтан, өрхийн эмч, тухайн хорооны нутаг дэвсгэрт байрлах сургуулийн нийгмийн ажилтан болон хорооны иргэдийн төлөөлөл болох 2-оос дээшгүй иргэн байж болно. Хорооны зөвлөлийн бүрэлдэхүүнийг хорооны Засаг даргын санал болгосноор хорооны иргэдийн Нийтийн Хурлын Тэргүүлэгчид батална. Хорооны зөвлөлийн нарийн бичгийн даргын үүргийг хорооны нийгмийн ажилтан гүйцэтгэнэ.

4.3. Зөвлөлийн дарга нь суманд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга, хороонд Засаг дарга байна.

4.4. Зөвлөл өрхийг тэтгэмжид хамруулах тухай шийдвэр гаргах явцад тухайн өрхийн амьжиргааны чадавхийг тогтоох зорилгоор хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх эрхтэй байна.

4.5. Зөвлөл тэтгэмжид хамрагдах өрхийг тогтоох ажлыг 10 хоногийн дотор шийдвэрлэсэн байна.

4.6. Сум, хорооны зөвлөлийн гаргасан шийдвэрт зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тамга, хорооны Засаг даргын тамгыг дарж баталгаажуулна.

4.7. Зөвлөл албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэж болно.

Тав. Тэтгэмж олголт

5.1. Тэтгэмж олгохдоо аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс (сумдад байцаагч) нь нийгмийн халамжийн бусад тэтгэмжийн нэгэн адил өрх бүрт тэтгэмжийн дэвтэр нээж, жагсаалтыг холбогдох банкны байгууллагад хүргүүлнэ.

5.2. Тэтгэмжийг сар бүрийн 30-ны дотор холбогдох банкаар дамжуулан олгоно.

Зургаа. Тэтгэмжийг зогсоох

6.1. Дараахь тохиолдолд сумын зөвлөл болон дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс тэтгэмж олголтыг зогсоож болно:

6.1.1. хүүхэд 18 нас хүрсэн;

6.1.2. хүүхэд үрчлэгдсэн;

6.1.3. хүүхэд нас барсан;

6.1.4. хүүхэд нь шүүхийн шийдвэрээр хорих ял эдлэх болсон;

6.1.5. хүүхэд нь орон гэрээсээ дайжиж хараа хяналтгүй болсон;

6.1.6. хүүхэд нь ерөнхий боловсролын сургуулиас завсардсан;

6.1.7. хүүхэд нь заавал хийх дархлаажуулалтад хамрагдаагүй;

6.1.8. хүүхэд нь тэвчишгүй хүнд хэлбэрийн хөдөлмөр эрхлэж байгаа;

6.1.9. өрхийн амьжиргааны чадавхи дээшилсэн.

6.2. Энэ журмын 6.1-д заасан шалтгаанаар тэтгэмж нь зогсоогдох хүүхдийн талаархи мэдээллийг эх, эцэг (асран хамгаалагч, харгалзан дэмжигч) нь сум, хорооны нийгмийн ажилтанд өгөх үүрэгтэй.

Долоо. Маргааныг хянан шийдвэрлэх

7.1. Өргөдөл гаргагч нь тэтгэмж олгох эсэх асуудлаар гаргасан зөвлөлийн шийдвэртэй санал нийлэхгүй тохиолдолд зөвлөлд гомдол гаргаж болно. Зөвлөл гомдлыг 1 сарын дотор дахин хянаж үзэж шийдвэрлэнэ.

7.2. Зөвлөлөөс дахин хянан үзэж гаргасан шийдвэрийг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд өргөдөл гаргагч харьяа хөдөлмөр, халамжийн үйлчилгээний байгууллага, нийгмийн хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон зохих шатны шүүхээр маргаанаа хянан шийдвэрлүүлнэ.

Найм. Бусад

8.1. Энэ журмын 6.1.2, 6.1.5, 6.1.6, 6.1.7, 6.1.8-д заасан шалтгаанаар тэтгэмж нь зогсоогдсон өрхийн хүүхэд гэртээ буцаж ирсэн, сургуульдаа эргэж орсон (албан бус сургалтад хамрагдсан), нөхөн дархлаажуулалтад хамрагдсан, хүүхдийн тэвчишгүй хүнд хөдөлмөр эрхлэхээ больсон тохиолдолд сумын зөвлөл болон дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн шийдвэрээр тэтгэмжийг үргэлжлүүлэн олгоно.

8.2. Засаг захиргааны шилжилт хөдөлгөөн хийгдсэн тохиолдолд шилжин ирсэн орон

нутгийнхаа засаг захиргаа, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст 1 сарын дотор бүртгүүлснээр тэтгэмж авах эрх үүснэ.

8.3. Сум, хорооны нийгмийн ажилтан нь орон нутгийн шилжилт хөдөлгөөнд хамрагдсан өрхийн 0-18 хуртэл насны хүүхдийн тайлан, мэдээг

сар бүр гарган аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст хүргүүлж байна.

8.4. Тэтгэмж олголын байдал болон тухайн жилийн туршид өрхийн амьжиргааны чадавхид гарсан өөрчлөлтөд аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс жил тутам үнэлгээ өгнө.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр

Дугаар 17

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

гаргахыг Сангийн сайд Н.Алтанхуягт зөвшөөрсүгэй.

Байгалийн гамшигт нэрвэгдсэн Бүгд Найрамдах Энэтхэг Улс, Тайландын Вант Улс, Бүгд Найрамдах Индонез Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Социалист Шри Ланк Улсад тус бүр 10 мянган ам.доллар, нийт 40 мянган ам.доллартай тэнцэх хэмжээний хөрөнгийг хүмүүнлэгийн тусламжид зориулан Засгийн газрын нөөц хөрөнгөөс

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Ц.ЭЛБЭГДОРЖ

САНГИЙН САЙД

Н.АЛТАНХУЯГ

ГАДААД ХЭРГИЙН
САЙД

Ц.МӨНХ-ОРГИЛ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 2 дугаар сарын 2-ны өдөр

Дугаар 20

Улаанбаатар хот

Төрийн өмчийн хорооны зарим гишүүнийг томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Пүрэвсүрэн, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Боловсролын газрын дарга Рэгсүрэнгийн Бат-Эрдэнэ нарыг тус тус томилсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Ц.ЭЛБЭГДОРЖ

САНГИЙН САЙД

Н.АЛТАНХУЯГ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 2 дугаар сарын 2-ны өдөр

Дугаар 22

Улаанбаатар хот

Итгэлцүүрийг шинэчлэн тогтоох, тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай

Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйл, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 30 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

3. Тэтгэвэр бодох хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг тооцоход хэрэглэх итгэлцүүрийг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан дараахь арга хэмжээ авахыг Сангийн сайд Н.Алтанхуяг, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ц.Баярсайхан нарт даалгасугай:

1. Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа тэтгэврийг шинэчлэн бодох болон шинээр тэтгэвэр тогтоолгоход баримтлах "Тэтгэвэр бодох хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг тооцоход хэрэглэх итгэлцүүр"-ийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

а/тэтгэвэр бодох хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг тооцох итгэлцүүрийг хэрэглэн тэтгэврийг шинэчлэн тогтоож 2005 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс тооцон олгох;

2. 1998 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс өмнөх хугацааны тэтгэвэр тогтоолгох сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг 120000 төгрөгөөр тогтоосугай.

б/шинэ итгэлцүүрийг хэрэглэсэн боловч тэтгэвэр нь өөрчлөгдөөгүй болон итгэлцүүрээр нэмэгдсэн хэмжээ нь 7.5 хувиас бага байгаа иргэдийн одоо авч байгаа тэтгэврийг 7.5 хувиар нэмэгдүүлэн 2005 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс тооцон олгох.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Тэтгэвэр бодох хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг тооцоход хэрэглэх итгэлцүүрийг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 1999 оны 10 дугаар сарын 1-ний өдрийн 157 дугаар тогтоолыг

хүчингүй болсонд тооцусгай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД** Ц.ЭЛБЭГДОРЖ

САНГИЙН САЙД Н.АЛТАНХУЯГ

**НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,
ХӨДӨЛМӨРИЙН САЙД** Ц.БАЯРСАЙХАН

*Засгийн газрын 2005 оны 22 дугаар
тогтоолын хавсралт*

ТЭТГЭВЭР БОДОХ ХӨДӨЛМӨРИЙН ХӨЛС, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ОРЛОГЫГ ТООЦОХОД ХЭРЭГЛЭХ ИТГЭЛЦҮҮР

№	Он	Хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг тооцоход хэрэглэх итгэлцүүр
1	1990 ба өмнөх онууд	100.0
2	1991	50.0
3	1992	19.2
4	1993	5.80
5	1994	4.20
6	1995	2.50
7	1996	2.00
8	1997	1.50
9	1998	1.30
10	1999	1.10
11	2000	1.07
12	2001	1.05
13	2002	1.03
14	2003	1.00

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 2 дугаар сарын 2-ны өдөр

Дугаар 24

Улаанбаатар хот

Тогтвортой байдлын гэрээний загвар батлах тухай

Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Гадаадын хөрөнгө оруулагчийн Монгол Улсад оруулсан анхны хөрөнгө оруулалтын хэмжээ нь 10.0 сая ам.доллар буюу түүнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөс дээш бөгөөд 15 жилээр байгуулах Тогтвортой байдлын гэрээний загварыг хавсралт ёсоор баталсугай.

2. Тухайн хөрөнгө оруулагчтай байгуулах Тогтвортой байдлын гэрээнд салбарын үйл ажиллагааны онцлог байдлыг харгалзан нэмэлт зүйл, заалт, тодруулгыг хууль тогтоомжийн хүрээнд оруулж байхыг Сангийн сайд болон холбогдох бусад сайд нарт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД** Ц.ЭЛБЭГДОРЖ

САНГИЙН САЙД Н.АЛТАНХУЯГ

*Засгийн газрын 2005 оны 24 дүгээр
тогтоолын хавсралт*

ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ГЭРЭЭ

Монгол Улсын Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн 19 дүгээр зүйл, ... хуулийн ... зүйлийн ... хэсэг (заалт)-ийг үндэслэн нэг талаас Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж Монгол Улсын Сангийн сайд (цаашид "Сайд" гэнэ), нөгөө талаас тогтвортой байдлын гэрээ байгуулахаар хүсэлт гаргасан ... улсад үүсгэн байгуулагдсан, аж ахуйн нэгжийн ... тоот улсын бүртгэлийн гэрчилгээтэй, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгуулахыг зөвшөөрсөн ... дугаартай гэрчилгээтэй ... үйл ажиллагаа явуулах ... компани буюу ... улсын иргэн ... (цаашид "хөрөнгө оруулагч" гэнэ) хөрөнгө оруулагчийн үйл ажиллагаа явуулах орчныг

тодорхой хугацаанд тогтвортой байлгах баталгаа болгож энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Гэрээгээр зохицуулах зүйл

1.1. Энэхүү Гэрээ нь хөрөнгө оруулагч Монгол Улсын аймаг (хот)-ийн сум (дүүрэг)-ын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулахад нь тогтвортой нөхцөлөөр хангах, тухайн хөрөнгө оруулалтын зорилго, хэмжээ, гэрээг цуцлах үндэслэл, хэрэгжүүлэх хугацаа, гэрээ байгуулагч талуудын эрх, үүрэгтэй холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу хөрөнгө оруулагчийн анхны хөрөнгө оруулалтын хэмжээ нь сая ам.доллар буюу түүнтэй тэнцэх төгрөгөөс дээш байх тул гэрээний хугацаа 15 жил байна.

1.3. Хөрөнгө оруулагчид үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ экспортод чөлөөтэй гаргаж, олон улсын зах зээлийн үнээр борлуулах, үүнээс олон төгрөгийн болон гадаад валютын орлогоо чөлөөтэй зарцуулахад нь хууль, эрх зүйн баталгаат нөхцөлөөр хангана.

1.4. Энэхүү гэрээ нь тухайн компанийн үндсэн үйл ажиллагаанд хамаарна.
Хоёр. Татварын орчин

2.1. Хөрөнгө оруулагч нь Татварын ерөнхий хуулийн 16, 17 дугаар зүйлд заасан татваруудыг энэхүү гэрээ хүчин төгөлдөр болох үед мөрдөгдөж байсан хууль тогтоомжид заасан хувь хэмжээгээр төлнө.

2.2. Хөрөнгө оруулагч өөрт ногдох орлогоосоо тухайн аж ахуйн нэгжид дахин хөрөнгө оруулалт хийвэл Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасны дагуу оруулсан хөрөнгийн хэмжээгээр хөрөнгө оруулагчийн тухайн аж ахуйн нэгжийн албан татвар ногдуулах орлогыг багасгаж тооцно.

2.3. Энэхүү гэрээ хүчин төгөлдөр болох үед үйлчилж байгаа Засгийн газраас баталсан тэргүүлэх ач холбогдол бүхий салбарт болон экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлд хөрөнгө оруулж байгаа гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж үйлдвэрлэл явуулахдаа технологийн зориулалтаар ашиглах, угсарч суурилуулах тоног төхөөрөмж, хүнд механизмыг импортын гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлнө.

2.4. Хөрөнгө оруулагчийн экспортод гаргасан бараа, ажил, үйлчилгээнд ногдуулах нэмэгдсэн өртгийн албан татварын хувь хэмжээ "0"-тэй тэнцүү байна.

2.5. Хөрөнгө оруулагчийн өөрийн хэрэгцээндээ зориулан Монгол Улсын нутаг дэвсгэрт худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд ногдох нэмэгдсэн өртгийн албан татварыг энэхүү гэрээ хүчин төгөлдөр болох үед мөрдөгдөж байсан нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

2.6. Хөрөнгө оруулагчийн өөрийн хэрэгцээнд зориулан импортлосон авто бензин, дизелийн түлшинд авто бензин, дизелийн түлшний онцгой албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар, авто бензин, дизелийн түлшний онцгой албан татвар болон гаалийн албан татварыг энэхүү гэрээ хүчин төгөлдөр болох үед мөрдөгдөж байсан хууль тогтоомжид заасан хувь хэмжээгээр ногдуулна.

2.7. Хөрөнгө оруулагчийн үйл ажиллагаанд

оролцон Монгол Улсад байнга болон түр хугацаагаар оршин сууж хөдөлмөр эрхэлж байгаа гадаадын иргэд хүн амын орлогын албан татварыг энэхүү гэрээ хүчин төгөлдөр болох үед мөрдөгдөж байсан хувь хэмжээгээр төлнө.

2.8. Хөрөнгө оруулагчийн үйл ажиллагаанд оролцож байгаа Монгол Улсын иргэд хүн амын орлогын албан татварыг энэхүү гэрээ хүчин төгөлдөр болох үед мөрдөгдөж байсан хувь хэмжээгээр төлнө.

2.9. Монгол Улсад оршин суугч бус хуулийн этгээдийн Монгол Улсад олон дараахь орлогод энэхүү гэрээ хүчин төгөлдөр болох үед мөрдөгдөж байсан Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын тухай хуульд заасан хувь хэмжээгээр албан татвар ногдуулна:

2.9.1. Монгол Улсад бүртгүүлэн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжээс авсан хувьцааны ногдол ашиг, хувь хүртэгчийн орлого;

2.9.2. Зээлийн хүү, батлан даалт гаргасны төлбөр;

2.9.3. Эрхийн шимтгэлийн орлого, түрээсийн төлбөр, биет болон биет бус хөрөнгө ашиглуулсны орлого;

2.9.4. Монгол Улсын төрийн байгууллага, аж ахуйн нэгж, бусад байгууллага, хувь хүнд үзүүлсэн техникийн болон бусад үйлчилгээний орлого.

2.10. Хөрөнгө оруулагч нь Монгол Улсад олон орлогын өөрт ногдох ашгаасаа гадаадад шилжүүлбэл шилжүүлсэн ашгаас энэхүү гэрээ хүчин төгөлдөр болох үед мөрдөгдөж байсан Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын тухай хуульд заасан хувь хэмжээгээр албан татвар ногдуулна.

Гурав. Газрын харилцаа

3.1. Хөрөнгө оруулагч нь үндсэн үйл ажиллагаандаа шаардагдах газар ашиглахтай холбоотой холбогдох зөвшөөрөл, лицензийг Газрын тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасан журмын дагуу авна.

3.2. Газар, газрын хэвлий ашигласны төлбөрийг Газрын тухай болон Газрын төлбөрийн тухай, Газрын хэвлийн тухай хуулийн дагуу тогтоох бөгөөд энэхүү гэрээг хүчин төгөлдөр болох үед мөрдөгдөж байсан хувь хэмжээгээр ногдуулна.

Дөрөв. Байгаль орчин

4.1. Хөрөнгө оруулагч байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн байдлын үнэлгээний тухай хууль тогтоомжид заасны дагуу байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн байдлын нарийвчилсан үнэлгээний тайланг боловсруулан хэрэгжүүлнэ.

4.2. Хөрөнгө оруулагч байгаль орчныг хамгаалах жил бүрийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг хариуцна.

4.3. Хөрөнгө оруулагч нь байгаль орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр, мониторингийн иж бүрэн сүлжээг өөрийн хөрөнгөөр бий болгож хэрэгжүүлнэ. Биелэлтийн үр дүн, мэдээллийг байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүрүүлнэ.

4.4. Хөрөнгө оруулагчийн хүсэлтийн дагуу ус ашиглах гэрээг Усны тухай, Усны төлбөрийн тухай болон бусад хууль тогтоомжид заасны дагуу байгуулна.

4.5. Төсөл хэрэгжүүлэгч нь эдэлбэр газрын экологи эдийн засгийн үнэлгээ, байгалийн нөөцийн даац чадавхийн хэмжээг төсөл хэрэгжүүлж эхлэхийн өмнө өөрийн хөрөнгөөр байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын гаргасан удирдамж, чиглэлийн дагуу мэргэжлийн байгууллагаар тогтоологж төлбөрийг улсын төсөвт шат дараатайгаар дээрх үнэлгээний хэмжээтэй адилаар төлж барагдуулна.

Тав. Дэд бүтэц

5.1. Хөрөнгө оруулагчийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой дэд бүтцийн асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

Зургаа. Хөдөлмөр, ажиллах хүч

6.1. Хөрөнгө оруулагч нь Монгол Улсын хөдөлмөр, нийгмийн хамгааллын холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

6.2. Хөрөнгө оруулагчийн үйл ажиллагаанд оролцож, түүнтэй хөдөлмөрийн гэрээ, контракт байгуулан ажиллаж байгаа Монгол Улсын иргэн нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд заавал хамрагдана.

6.3. Хөрөнгө оруулагчийн үйл ажиллагаанд оролцож байгаа гадаадын иргэд нь нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд сайн дураараа хамрагдаж болно.

6.4. Хөрөнгө оруулагч нь гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авахдаа Монгол Улсын Засгийн газраас тогтоосон тухайн жилийн гадаадаас авах ажиллах хүчний квотыг мөрдөнө.

6.5. Хөрөнгө оруулагч нь гадаадын иргэнийг ажлын байраар хангаж, орлого бүхий ажил, үйлчилгээ эрхлүүлсний төлөө төлөх ажлын байрны төлбөр нь энэхүү гэрээ хүчин төгөлдөр болох үед мөрдөж байсан хууль тогтоомжид заасны дагуу зохицуулагдана.

6.6. Хөрөнгө оруулагч нь үйл ажиллагаандаа Монгол Улсын болон Олон улсын эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүйн ажиллагааны стандартыг мөрдөнө.

Долоо. Хөрөнгө оруулагчийн эрх, үүрэг

7.1. Хөрөнгө оруулагч нь гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж, Монгол Улсын хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

7.2. Хөрөнгө оруулагч нь Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгжид олгодог эрх, нөхцөлөөр адил хангагдана.

7.3. Хөрөнгө оруулагч нь өөрийн эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхтэй.

7.4. Хөрөнгө оруулагч нь Монгол Улсын болон гадаад орны банкнд данс нээж өөрийн сонгосон валютаар чөлөөтэй, саадгүйгээр гүйлгээ хийж болно.

7.5. Энэхүү гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дараагийн жилийн мөн өдрийг хүртэлх хугацааг энэхүү гэрээний хувьд "Хөрөнгө оруулалтын жил" гэж үзнэ.

7.6. Хөрөнгө оруулагч гэрээ байгуулагдах үед анхны хөрөнгө оруулалтын хэмжээ нь 10.0 сая ам.доллар буюу түүнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөс дээш хөрөнгийг Монгол Улсын нутаг дэвсгэрт оруулсан байна. Энэхүү гэрээнд гарын үсэг зурснаас хойш Монгол Улсын нутаг дэвсгэр дээр . . . жилийн хугацаанд нийт . . . сая ам.долларын нэмэлт хөрөнгө оруулалтыг дараахь хуваарийн дагуу хийнэ:

№	Хугацаа	Хөрөнгө оруулалтын хэмжээ (сая ам.доллар)	Мөнгө хэлбэр	Бусад хэлбэр
1	200 оны сарын нөх өдөрөөс 200 оны сарын нөх өдөр хүртэл			
2	200 оны сарын нөх өдөрөөс 200 оны сарын нөх өдөр хүртэл			
3	200 оны сарын нөх өдөрөөс 200 оны сарын нөх өдөр хүртэл			

7.7. Хөрөнгө оруулагч нь тухайн хөрөнгө оруулалтын жилд оруулсан хөрөнгө оруулалтын тайлангаа дараагийн хөрөнгө оруулалтын жилийн эхний сард багтаан Сангийн яамнаас баталсан маягтын дагуу гаргаж, тухайн салбарын болон бусад холбогдох төрийн захиргааны төв байгууллагуудаар хянуулан Сайддад хүргүүлнэ.

7.8. Хөрөнгө оруулагч нь санхүүгийн тайлангийн аудитыг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн нягтлан бодох бүртгэлийн аудитийн компаниар хийлгэсэн байна.

7.9. Хөрөнгө оруулагч бүтээгдэхүүнээ борлуулснаас олсон орлогын талаархи мэдээллийг үнэн зөв, тухай бүрт нь гаргаж өгнө.

7.10. Хөрөнгө оруулалтыг бэлэн мөнгө, техник, тоног төхөөрөмж, түүхий эд, бараа материал, оюуны өмч болон хуулиар зөвшөөрөгдсөн бусад байдлаар хийх эрхтэй.

7.11. Сайд энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйн улмаас Тогтвортой байдлын гэрээний баталгаа алдагдсан тохиолдолд Хөрөнгө оруулагч баталгааг сэргээлгэх, учирсан хохирлоо нөхөн төлүүлэхээр хуульд заасан журмын дагуу нэхэмжлэл гаргах эрхтэй.

Найм. Сайдын эрх, үүрэг

8.1. Хөрөнгө оруулагчийн үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн болон санхүүгийн орчныг гэрээний

хугацааны турш тогтвортой байлгах талаар энэхүү Гэрээнд заасан баталгаа, нөхцөлөөр хангах үүргийг хүлээнэ.

8.2. Энэхүү гэрээнд гарын үсэг зурсны дараа уг гэрээний нөхцөлийн тухай мэдэгдлийг холбогдох газруудад хүргүүлнэ.

8.3. Хөрөнгө оруулагч энэхүү гэрээний 7.6-д заасны дагуу хөрөнгө оруулалт хийх үүргээ биелүүлэлгүй 6 сар өнгөрвөл Сайд энэ тухай Хөрөнгө оруулагчид албан бичгээр мэдэгдэл өгнө.

8.4. Мэдэгдэл өгснөөс хойш ажлын 60 хоногийн дотор Хөрөнгө оруулагч уг мэдэгдэлд заасан үүргийг биелүүлэх талаар зохих арга хэмжээ аваагүй тохиолдолд Сайд гэрээг дангаар цуцлах эрхтэй.

8.5. Сайд хөрөнгө оруулагчид үйл ажиллагаагаа сэргээхийг шаардсан албан мэдэгдлийг өгснөөс хойш ажлын 120 өдрийн дотор үйл ажиллагаагаа сэргээгүй тохиолдолд гэрээг дангаар цуцална.

Ес. Хөрөнгө оруулагчийн хамгаалалт

9.1. Хөрөнгө оруулагч нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр Монгол Улсын хууль тогтоомж болон Монгол Улсын олон улсын гэрээгээр баталгаажсан эрх зүйн хамгаалалттай байна.

9.2. Хөрөнгө оруулагчийн Монгол Улсад оруулсан хөрөнгө оруулалтыг Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хууль бусаар хураан авахыг хориглоно.

9.3. Хөрөнгө оруулагчийн хөрөнгийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр нөхөн төлөх нөхцөлөөр дайчлан гаргуулж болно.

9.4. Хөрөнгө оруулагчид өөрийн хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулахад нь Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгжид олгодогтой адил тааламжтай нөхцөл олгоно.

Арав. Гэрээ дуусгавар болох

10.1 Дараахь тохиолдолд гэрээ дуусгавар болно:

10.1.1. Гэрээний хугацаа дууссан тохиолдолд;

10.1.2. Гэрээний үүргийг бусдад шилжүүлсэн тохиолдолд;

10.1.3. Хөрөнгө оруулагч гэрээг цуцлах тухай хүсэлт гаргасны дагуу хоёр тал харилцан тохиролцсон тохиолдолд;

10.1.4. Аж ахуйн нэгж дампуурсан, хууль тогтоомж зөрчсөний учир эрх бүхий байгууллагаас үйл ажиллагааг нь бүрэн зогсоосон болон Сайд үйл ажиллагаагаа сэргээхийг шаардсан албан мэдэгдлийг Хөрөнгө оруулагчид өгснөөс хойш ажлын 120 өдрийн дотор үйл ажиллагаагаа сэргээгээгүй тохиолдолд.

Арван нэг. Давагдашгүй хүчин зүйл

11.1. Байгалийн гамшиг, нийтийг хамарсан халдварт өвчний улмаас энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ бүгдийг, эсхүл аль нэгийг нь биелүүлээгүй бол ийнхүү биелүүлээгүйн улмаас гарах үр дагаварт талууд хариуцлага хүлээхгүй.

Арван хоёр. Маргаан шийдвэрлэх

12.1. Энэхүү Гэрээний үүргийн биелэлттэй холбогдон үүссэн аливаа маргааныг дор дурдсанаар шийдвэрлэнэ:

12.1.1. Маргааны талаар нөгөө талд бичгээр хандаж мэдэгдэл гаргана. Талууд уг маргааныг эв зүйгээр харилцан тохиролцож шийдвэрлэнэ;

12.1.2. Хэрэв талууд харилцан тохиролцож чадаагүй тохиолдолд Улсын Арбитрын шүүхээр шийдвэрлүүлнэ.

12.2. Энэхүү гэрээтэй холбогдсон аливаа маргаантай асуудлыг хянан шийдвэрлэхэд Монгол Улсын хууль тогтоомжийг хэрэглэнэ.

Арван гурав. Бусад зүйл.

13.1. Уг Гэрээ нь Засгийн газрын холбогдох байгууллагуудтай бие даан үйл ажиллагааны гэрээ хийх хөрөнгө оруулагчийн эрхийг хязгаарлахгүй.

13.2. Гэрээг 200 ... оны ... сарын ...-ны өдөр Улаанбаатар хотод Монгол, хэл дээр хоёр хувь үйлдэж баталгаажуулав.

13.3. Хувиуд адил хүчинтэй байна.

13.4. Гэрээний хэрэгжилттэй уялдуулан талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү гэрээнд бичгээр нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

13.5. Оролцогч бүх тал гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулсан өдрөөс эхлэн гэрээ хүчин төгөлдөр болно.

13.6. Гэрээний хэрэгжилттэй уялдуулан Хөрөнгө оруулагчийн хүсэлтийг үндэслэн гэрээг жилээр сунгаж болно.

Гэрээ байгуулсан талууд:

Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж:

Огноо: _____

Хөрөнгө оруулагчийг төлөөлж:

Огноо: _____

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гарав.

"Төрийн Мэдээлэл" эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар- 12,

Төрийн ордон

☎ 329612

Индекс 14003

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын

Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 329487

Хэвлэлийн хуудас 1.5